

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ БАЯНХОНГОР АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР  
/2026 ОНЫ ХАГАС ЖИЛ/

2026 оны 06 дугаар сарын 22

Номгон

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ
1	2	3	4	5	6
<b>УИХ-ын байгын хорооны тогтоол</b>					
1	1	Тогтоолын хэрэгжилтийг хангуулах	1.2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр (2024-2030)-ийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангаж, жил бүр тайлагнах;	Тус хөтөлбөрийн хүрээнд байгууллагын албан хаагчдад чиглэсэн 5 ажил арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн цахимаар албан хаагчдын санал бодлыг сонсох үйл ажиллагааг зохион байгууллаа.	60%
	2	талаар авах арга хэмжээний тухай 2024-11-06 Дугаар 2024_06 ЭЗДБХ	1.3. Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлж, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг таниулах сургалтыг зохион байгуулж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллах.	Ёс зүйн дэд хорооноос нийт албан хаагчдаас цахимаар ёс зүй, харилцаа хандлагын талаар санал асуулгыг авч нэгтгэлээ. Тус саналд 23 хүн оролцлоо. саналын дагуу танхимын сургалтыг 1 удаа зохион байгуулж холбогдох гарын авлага, боршур бэлтгэн цахимаар түгээж ажиллалаа.	50%
2	3	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЭЗДБХ	1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах;	Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хэрэгжүүлэх арга хэмжээг байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангаж ажиллахын зэрэгцээ тухай бүр тайлагнан ажиллаж байна.	100%
	4		1.1.3.3/Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хангах зохицуулалт хийх.	Байгууллагын ёс зүйн дэд хороог Газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/11 дугаартай тушаалаар дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгууллагаа. Ёс зүйн дэд хорооны даргаар	100%

1	2	3	4	5	6
	5		1.3.1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах.	С.Идэрбаясгалан, гишүүд Б.Мөнхнасан, Б.Бат-эрдэнэ нар томилогдон хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.	
				Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшуулал олгох асуудал нь Төвийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд болгх боломжгүй байна.	100%

**Ерөнхийлөгчийн зарлиг**

3	6	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.8. Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	Тайлант хугацаанд иргэд, хүүхэд залуучуудыг биеийн тамир, спортоор чиглэлээр нийт 42 спортын арга хэмжээ зохион байгуулж, нийт 32.410 тамирчин, иргэнийг, энэ чиглэлийн 8 төрлийн секц, дугуйлан тогтмол үйл ажиллагаа явуулж, 5–18 насны 205 эрэгтэй, 99 эмэгтэй нийт 304 хүүхдийг тус тус байна. Дээрх арга хэмжээнүүдэд “Наран мандал энтеррайзес”ХХК 25.0 сая, “Би Өү Эл Ди майнин” ХХК 10.0 сая, “Одод голд” ХХК 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн хамтран ажилласан байна. Үүний үр дүнд: • Аймаг, орон нутгийн иргэд, хүүхэд залуучуудын спортын оролцоо, идэвх мэдэгдэхүйц нэмэгдсэн, Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөл сайжирсан байна.	100%
4	7	Тэрбум мод үндэсний өдөр зарлах тухай 2025-04-03 Дугаар 2025_44	1.. Жил бүрийн 5, 9 дүгээр саруудын Бямба, Ням гаралуудыг тэрбум мод тарих үндэсний өдөр болгон зарласгай. 2. Тэрбум мод үндэсний өдрийн хүрээнд бүх нийтээр мод, сөөг тарих, арчлан ургуулах үйл хэрэгт идэвхтэй оролцож, сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэхийг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хөгжлийн түнш байгууллагууд, хандивлагч нарт уриалсугай.	МУ-ын ерөнхийлөгчийн хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төлөвлөгөө гарган Газрын даргаар батлуулж, байгууллагын хуваарьт газарт өмнө тарьсан Улиас модны амьдрах түвшинг шалгалт хийж, нийт тарьсан 52 модноос ургах чадваргүй 42 ширхэг модыг нөхөн суулгаж , нэмж 56 ширхэг модыг тарьж нийт 64 ширхэг Улиас модонд усалгаа арчилгааг тогтмол хийж	100%

1	2	3	4	5	6
				ажиллагаа. Мөн байгууллагын гадна тожилтод 7 ширхэг Гацуур, 9 ширхэг чацарганы модыг нэмж тарьж ажиллагаа.	
<b>ЗГ-ын тогтоол</b>					
5	8	Төрийн байгууллагын үйл ажиллагааны талаар зарим арга хэмжээний тухай Дугаар 2026_119	4.. 4.Төрийн байгууллагын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй, шуурхай байдлыг алдагдуулахгүйгээр Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу төрийн албан хаагчийг долоо хоногийн ажлын нэг өдөр зайнаас цахим сүлжээгээр ажиллуулах, ажлын цагийг уян хатан байх дотоод зохион байгууллагын арга хэмжээ авах, хуульд зааснаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын өдрүүд болон долоо хоногийн амралтын өдрүүдэд ажиллуулахгүй байхыг төсвийн шууд захирагч нарт даалгасгай.	Байгууллагын нийт албан хаагчдын хурлыг зарлан хуралдуулж санал авч ажлын өдөр цахимаар ажиллах ажилтан байхгүй, цагийн зөрүүтэй ажиллах 1 албан хаагч, нийтээр амрах баярын өдрүүд болон долоо хоногийн амралтын өдрүүдэд ажиллуулсан тохиолдолд нөхөн амраах талаар албан хаагчид санал тохиролцон хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
6	9	Бизнесийн орчныг дэмжих зарим арга хэмжээний тухай Дугаар 2026_127	5.. 5.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болон төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг дэмжихээс бусад зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системийг шинээр хөгжүүлэхэд төсвийн хөрөнгө зарцуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт хориглосугай.	Тайлант хугацаанд Байгууллагын дотоод үйл ажиллагааг дэмжихээс бусад зорилгоор төрөөс иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системийг шинээр хөгжүүлэхэд төсвийн хөрөнгө зарцуулаагүй ажиллаж байна.	100%
<b>Ерөнхий сайдын захирамж</b>					
7	10	Нийгэмд шуударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 2025_64	5.Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шуударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, нийт төрийн албан хаагчдад үүрэг болгосугай.	Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 19 арга хэмжээний хүрээнд боловсруулан газрын даргаар батлуулж, 9 арга хэмжээний хэрэгжилтийг ханган тайланг тухай бүр заасан хугацаанд холбогдох газруудад хүргэн ажилласан.	100%
<b>ЗГ-ын хуралдааны тэмдэглэл</b>					
10.4.1. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг доор дурдсан албан тушаалтнуудад даалгав			Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 5 төрлийн 4б		

1	2	3	4	5	6
8	11	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-02 Дугаар 2025_15	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсанд болон нээлттэй мэдээллийн системд 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Узүүлэлт тус бүрийн мэдээллийг 1, 1-р улирлын байдлаар байгууллагын албан ёсны сайт <a href="https://baialkhongor.sport.gov.mn/">https://baialkhongor.sport.gov.mn/</a> болон <a href="https://shien.gov.mn/home">https://shien.gov.mn/home</a> сайгад байршуулж ажилласан. Мөн Шилэн дансны цахим хуудсанд нээлттэй байршуулах цахим хуудсанд нээлттэй холбоотой 59 мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу тогтоосон хугацаанд иж бүрэн үнэн зөв байршуулан ажилласан байна. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд нийт 105 мэдээллийг ил тод байршуулан ажилласан.	100%
9	12	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-10 Дугаар 2025_16	28.1.3.Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн мэдээллийн санд тухай бүр бүртгүүлж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Тайлант хугацаанд байгууллагад нийт 27 өргөдөл, гомдол ирснийг тус бүрийг дугаарлаж, бүртгэлийн дардас дарж, бүртгэлийн дэвтэрт бүртгэн ажилласан. Ирсэн өргөдөл, гомдлыг агуулгаар нь ангилж үзвэл ажилд орохыг хүссэн-1, дотоод журмын дагуу чөлөө хүссэн-2, ажлаас гарахыг хүссэн-1, хүсэлт-2, ээлжийн амралт хүссэн-1, нийт 27 өргөдөл гомдлыг хүлээн авч холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу хуулийн хугацаанд шийдвэрлэж өргөдөл гомдлын мэдээг төрийн захиргааны удирдлагын хэлтэст тогтсон хугацаанд хүргүүлэн ажилласан. Мөн хүлээн авсан өргөдөл, гомдлыг /eoffise.baialkhongor.gov.mn/ программд бүртгэн шивж сканердан оруулан ажиллаж байна.	100%
	13		28.2.1.1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг даалгав: 1.1.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг	Байгууллагын зүгээс хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулан гаргахгүй, санхүү, төсвийн	100%

1	2	3	4	5	6
	14		<p>Боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулан гаргахгүй байх, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарах;</p> <p>1.2.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг товч тодорхой, үнэн, зөв тайлагнах;</p> <p>1.3.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны зохицуулалтад шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэх;</p> <p>1.4.хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахдаа салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, хэрэгжилтийг тогтмол хянаж, үр дүнг нэмэгдүүлж ажиллах.</p> <p>28.14.1.3.Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулж ажиллаагүй байгууллага, албан тушаалтанд хууль, гэрээнд заасны дагуу харилцлага тооцож ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт.</p>	<p>асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байх, хэрэгжилт, тайланд арга хэмжээг нэгтгэх, үр дүнг тодорхой тайлагнах, шаардлагатай хөрөнгө төсвийг шийдвэрлүүлэх, өмнөх оны үзүүлэлтийг суурь түвшнөөр тодорхойлох зэрэг арга хэмжээ авч ажиллаж байна.</p>	
10	15	<p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-10-08 Дугаар 2025_20</p>	<p>16.4.3.2.Төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (system.gov.mn)-д бүртгүүлэх;</p>	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 5 төрлийн 46 үзүүлэлт тус бүрийн мэдээллийг I, II-р улирлын байдлаар байгууллагын албан ёсны цахим сайт <a href="https://baaankhongor.sport.gov.mn/">https://baaankhongor.sport.gov.mn/</a> болон <a href="https://shien.gov.mn/home">https://shien.gov.mn/home</a> сайтад байршуулж ажилласан.</p>	100%

1	2	3	4	5	6
11	16	<p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 26 дугаар</p> <p>Хуралдааны тэмдэглэл 2025-11-05</p> <p>Дугаар 2025_26</p>	<p>13.3.1.2.1.2. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хангалтгүй дүгнэгдсэн заалтын хэрэгжилтийг эрчимжүүлж, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөө боловсруулах, салбарын хэмжээнд бодит үр дүнг сар бүр нэгтгэн дүгнэж, товч, тодорхой тайлагнах, өмнөх сард тайлагнасан албан даалгаврын хэрэгжилтийг давтан тайлагнахгүй байх.</p>	<p>Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хангалтгүй дүгнэгдсэн заалт байхгүй.</p>	100%
12	18	<p>15.5.1.Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав: Шинэ итгэл-Эрс шинэчлэл: Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан байгууллагын 4 жилийн стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, 2026 оны тэргүүлэх чиглэлийн бодлого зорилтыг иргэдийн төлөө уриатайгаар тодорхойлж ажиллах.</p>	<p>13.3.7.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилголт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг хязгаарлаж, уулзалт, сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж ажиллахыг төрийн байгууллагын удирдлага, албан тушаалтнуудад даалгав;</p>	<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад, дотоод томилголт, өндөр өртөгтэй автомашин, тавилга хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг худалдан авах, зардал өндөртэй сургалт зөвлөгөөн зэрэг арга хэмжээг зохион байгуулж ажиллаагүй.</p>	100%
12	19	<p>15.5.2.2.Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд заасан зорилго, зорилтыг байгууллагын стратеги төлөвлөгөө болон төрийн захиргааны байгууллага, албан хаагчийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах;</p>	<p>Биеийн тамир, спортын улсын хорооноос тайлант хугацаанд стратеги төлөвлөгөө батлаагүй боловч Монгол улсын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан /иргэдийн биеийн жингийн индекс, спортын заал талбайн хүрэлцээ хангамж нэмэгдүүлэх, спортоор хичээллэгсдийн тоо нэмэгдүүлэх/ салбарын чиг үүрэгтэй холбоотой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	<p>Монгол улсын хөгжлийн урт, богино, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээнүүдийг байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж холбогдох даргаар багтуулан хэрэгжилтийг ажиллаж байна.</p>	100%
20		<p>15.5.3.3.Байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгасан зорилт, зорилго нь төрийн захиргааны байгууллагын</p>	<p>Байгууллагын зорилго зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг нэрж болон</p>	<p>100%</p>	

1	2	3	4	5	6
			<p>Болон албан хаагчийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээтэй уялдсан байх, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийн түвшин нь хэмжигдэхүйц, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдсэн байх, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөж, боловсруулах;</p> <p>15.5.5.5.Төрийн аудитын байгууллагаас төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангаж, зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн хэрэгжилтийг тайлагнахад хариуцлагатай байх, ил тод байдлыг хангаж ажиллах.</p>	<p>албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, үр дүнг бодитоор илэрхийлэх үр дүн хэмжигдэхүйц байдлаар хийж ажилласан. Хэрэгжилтэд шаардлагатай санхүүгийн тооцооллыг арга хэмжээ тус бүрээр тодорхойлж боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэдэг санхүүгийн тайлантын хяналт шалгалтаар зөрчилгүй дүгнэлттэй ажилласан.Тайлант хугацаанд Төсөв санхүүгтэй холбоотой хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.</p>	100%
21		<p>Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 28 ний өдрийн 04 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-01-28 Дугаар 2026_04</p>	<p>19.1.1.1."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов;</p>	<p>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	100%
13	22	<p>Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25 ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-02-25 Дугаар 2026_07</p>	<p>19.2.4.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов;</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын "2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийг байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	100%
14	23	<p>Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 02 дугаар сарын 25 ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-02-25 Дугаар 2026_07</p>	<p>15.2.1.1.1.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт дараах арга хэмжээ авахыг үүрэг болгов: 1.1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг ханган бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх;</p>	<p>Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг эрчимжүүлж, салбар хоорондын уялдааг ханган тогтмол цаглаварт хугацаанд цахим болон цаасан хэлбэрээр мэдээ тайланг холбогдох байгууллагуудад тухай бүр хүргүүлэн ажиллаж байна.</p>	100%
	24		<p>15.2.1.3.. 1.3.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа зохицуулалт, утга агуулгын хувьд давхардал, хийдэл, зөрчилтэй шийдвэр гаргахгүй байх, санхүүгийн эх үүсвэрийг тусгах, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт хэрэгжихүйц байхад анхаарах.</p>	<p>Өдөр тутмын үйл ажиллагаандаа хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа зохицуулалт, утга агуулгын хувьд давхардал, хийдэл, зөрчилтэй шийдвэр гаргалгүй, санхүүгийн.</p>	100%

1	2	3	4	5	6
		Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэл 2026-03-25 Дугаар 2026_11	22.4.1.1... Төрийн байгууллага, хувийн хэвшил хэмнэлтийн горимд шилжих, төсвийн зардлыг хэтрүүлэхгүй байх, сахилга харууллага, дэг журмыг чангатгах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгов: 1.1.төсвийн сахилга батыг сайжруулж, хэмнэлтийн горимд шилжих, төсвийн хэмнэлт гаргах замаар нэмэлт санхүүжилтийн хэрэгцээг хангах;	эх үсвэрийг тусгах, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт хэрэгжихүйц байхад анхаарч ажиллаж байна.	100%

ХЯНАСАН:

ДАРГЫН АЛБАН ХҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ *Д. Нуртүвшин* ХҮРЭЛЧУЛЛУУН

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН  
ЭРХЛЭГЧ *Д. Билтүвшин* ДӨЛЖИНСҮРЭН

